

TECEB



Зорилт:

- Орлого, зарлагын талаарх үндсэн ойлголтын хүрээнд төсвийн талаар тайлбарлах



Сэдвийн агуулга:

- Ангийн төсөв
- Орлого, зарлага
- Улсын төсөв

Сургалтын арга:

- Хувийн төсвийн тооцооллыг гаргах
- Лекцийн арга

Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- "Төсөв" видео

Түлхүүр үг:

Мөнгө

Бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт ашиглах төлбөрийн хэрэгсэл.

Төсөв

Хувь хүн, албан байгууллага, улс орны тодорхой хугацаанд зарцуулахаар тооцоолон төлөвлөсөн орлого, зарлагын ерөнхий төлөвлөгөө.

Төгрөг

Монгол Улсын мөнгөн дэвсгэрт.

Орлого

Хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө авсан, эсхүл бүтээгдэхүүн үйлчилгээг зарж борлуулснаас олсон мөнгөн орлого.

Зарлага

Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа зарцуулсан мөнгө.

Хуримтлал

Ирээдүйн хэрэгцээнд зориулан хадгалж, хуримтлуулсан мөнгө.

Үйл ажиллагаа

1. Сэдэлжүүлэлт

- Сурагчдын өмнөх мэдлэгийг илрүүлэхийн тулд дараах асуултыг асууна.
Үүнд:
 - Мөнгө гэж юу вэ?
 - Орлого, зарлага гэж юу вэ?

2. Шинэ мэдлэг бүтээх

- “Төсөв” видеог үзүүлнэ.
- Сурагчийн гарын авлага дээрх мэдээллийг бие даан уншуулна. Үүний дараа багш төсвийн үндсэн бүрдэл болох орлого, зарлага, хуримтлалын талаар тайлбарлаж өгнө.
- Хувь хүний төсөвтэй дүйцүүлэн улсын төсвийн талаар тайлбарлана.

3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

Дасгал ажил 1.

Дасгалын хуудсан дээрх зургийн дагуу өөрийн төсвийг төлөвлөн бичнэ.

Хяналтын асуулт:

1. Орлого гэж юу вэ? Чиний орлого хэрхэн бүрддэг вэ?
2. Зарлага гэж юу вэ? Юу юунд зарцуулагддаг вэ?
3. Чамд хуримтлал байдаг уу? Хуримтлалыг яагаад бий болгох ёстой вэ?
4. Төсөв гэж юу вэ? Төсөв зохиохын ач холбогдлыг тодорхойлно уу.

Дасгал ажил 1.

ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛ

ОВОГ, НЭР: _____
АНГИ: _____

МИНИЙ ТӨСӨВ

Миний оны сарын төсөв

<p>▼ ОРЛОГО</p> 	<p>▲ ЗАРЛАГА</p> 
<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>НИЙТ: _____</p>	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>НИЙТ: _____</p>
<p>▶ ХУРИМТЛАЛ</p> 	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>НИЙТ: _____</p>

Найзууд аа, сар бүр төсөө тооцоолж, хуримтлал үүсгээрэй!

